

ЭРЭН ХАЙХ, АВРАХ АЖИЛЛАГААНД АЛБАНЫ НОХОЙ АШИГЛАХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Хураангуй. Энэхүү нийтлэлээр Монгол Улсын онцгой байдлын албаны эрэн хайх, аврах ажиллагаанд албаны нохой ашиглах хэрэгцээ шаардлагыг олон улсын эрэн хайх, аврах ажиллагааны жишээн дээр дэвшүүлэн гаргахыг зорилоо.

Түлхүүр үг. Онцгой байдлын алба, эрэн хайх, аврах ажиллагаа, албаны нохой, эрэлч нохой. гамшиг, осол.

Эрэн хайх, аврах ажиллагааны талаар авч үзэхийн тулд юуны өмнө зарим нэр томъёо. эрх зүйгээс эхлэх нь зүйтэй гэж үзлээ.

Аврах ажил¹ - элдэв аюулаас хэлтрүүлэх. дээрээс өршөөн үзэж туслах гэсэн утгыг илэрхийлнэ.

Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуульд "Аврах ажиллагаа гэж гамшгийн аюулын үед хүн, мал, амьтан, эд хөрөнгө, түүх соёлын дурсгалт зүйлсийг эрж хайх, аврах, гал түймрийн шаталтыг зогсоох, унтраах, нэрвэгдэгсдэд анхны тусламж үзүүлэх, гамшгийн голомтоос гаргах, хор уршгийг арилгах үйл ажиллагааг хэлнэ" гэж тодорхойлсон.

Мөн НҮБ-аас гамшгийн үед эрэн хайх, аврах чиглэлээр гаргасан урт хугацаанд хэрэгжүүлэх зөвлөмжөөр ОБЕГ нь эрэн хайх ажиллагаа явуулах арга, техникийг нэмэгдүүлэх. Тухайлбал дуу авианы хэрэгсэл, эрэл хийх камер, эрэлч нохойн алба^{1 2} ашиглах.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2014 оны А/339 дугаар тушаалаар батлагдсан эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах нийтлэг журмын 3 дугаар бүлгийн 3.24 зүйл “Эрэн хайх, аврах ажиллагаанд тусгайлан бэлтгэсэн эрэлч нохойг ашиглана” гэсэн зүйл заалтыг тус тус тусгасан байна.

Дээрх дурдагдсан эрх зүйг үндэслэн судлаач миний бие энэхүү нийтлэлээрээ гамшиг ослын үед эрэн хайх, аврах ажлыг оновчтой, хурдан шуурхай зохион байгуулах, хүний амь нас, эд хөрөнгө, байгаль

¹ Б.Баярсайхан. Монгол хэлний тайлбар толь. УБ., 2011.

² “НҮБ”-ын Эрэн хайх, аврах олон улсын зөвлөлдөх бүлгийн үнэлгээний багийн гаргасан зөвлөмж. УБ., 2014. 15 дугаар зүйл.

орчинд учрах хохиролыг аль болох бага байлгах үр дүнтэй ажиллагааг явуулахын тулд онцгой байдлын байгууллагад албаны нохой ашиглах хэрэгцээ шаардлага байгааг тодорхойлохыг зорилоо.

Онцгой байдлын ерөнхий газрын харъяа Гамшиг судлалын хүрээлэнгээс гаргасан сүүлийн 10 жилийн судалгаагаар жил бүр байгаль цаг агаарын аюулт үзэгдлийн холбогдолтой осол 40 хувь, хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй болон бусад осол 65 хувиар өсөж, аюулт үзэгдэл, ослын цар хүрээ улам ихээр нэмэгдэж байгаа нь статистик тоон үзүүлэлтээс харахад хангалттай байна.

Эдгээр аюулт үзэгдэл, ослын төрлүүдээс байгалын цаг агаарын гаралтай аюулт үзэгдэл, хүний үйл ажиллагаатай холбоотой зэрэг ослуудад албаны нохой ашиглах хэрэгцээ шаардлага бий болсон гэдэгт та бүхэн санал нэгдэх байх.

Дээрх гамшиг ослыг бууруулах зорилгоор урьдчилан сэргийлэх, тэмцэх, хор уршгийг арилгах, сэргээн босгох үйл ажиллагаанд ард иргэд, төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, гамшгаас хамгаалах улсын албадын хүч хэрэгслийг татан оролцуулах, тэдний үйл ажиллагааг уяалдуулан зохицуулах, нэгтгэх, харилцан хамтын ажиллагааг сайжруулах талаар онцгой байдлын байгууллага тодорхой үр дүнтэй ажилуудыг амжилттай зохион байгуулж ирсэн.

Хүн ам ихээр төвлөрсөн томоохон суурин газрууд нь ихэвчлэн газар хөдлөлтийн идэвхитэй бүсэд оршдог бөгөөд газар хөдлөлтийн гамшгийн үед их хэмжээний барилгын нуранги үүсэж оршин суугчид олноор өртөж хүрээлэн буй орчинд аюул үүсэх магадлал, эрсдэл улам бүр нэмэгдэж байгаа өнөө үед нурангид дарагдсан сураггүй алга болсон нэрвэгдэгсдийг шуурхай олох, хот суурин газарт эрэн хайх, аврах арга хэмжээг нэн яаралтай зохион байгуулахад эрэлч нохойн үүрэг оролцоо чухал хэрэгцээтэй байгаа нь олон улс оронд тохиолдсон газар хөдлөлтийн гамшиг үүссэн цаг хугацааны эх сурвалжаас харагдаж байна. Жишээбэл: 1995 онд Япон (Кобе) 11 балл, 1999 онд Тайвань (Чи-Чи) 8.0 балл, 2010 онд Гаити 7.0 балл, 2011 онд Япон 9.1 баллын аюул дагуулсан газар хөдлөлт болсон байна.

Дэлхийн олон оронд эрдэм шинжилгээний сорил туршилт, аж ахуй, соёл урлагын үйл хэрэгт нохойг ашиглахаас гадна тэдгээрийн гойд хөгжсөн мэдрэмж үнэрлэх, сонорын эрхтэнг ашиглан батлан хамгаалах болон гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөн илрүүлэх, хил хамгаалах, төрөл бүрийн гамшиг ослын үед эрэн хайх, аврах

ажиллагаанд олон зуун жилийн тэртээгээс нохойн албыг байгуулан өргөнөөр ашиглаж ирсэн түүхэн уламжлалтай.

Нохой нь хагас сая үнэрийг төрөлжүүлэн ялгаж үнэрлэх чадвартай ба хүнийхээс 1 сая дахин их, сонсох чадвар нь 400 дахин бага дууны хэлбэлзлэлийг сонсож чаддаг 1000 м нэгж талбайд газарт хүн 1 цаг хайдаг бол нохой 20 минутанд бүрэн гүйцэд эрж хайдаг ийм газарт машинаар 30 км цагийн хурдтай явахад хүн 50 м газарт хараагаар үзэгдэх орчинг харж хайдаг бол нохой үнэр болон сонсголоо хослуулж эрэн хайдаг нь судалгаагаар тогтоогдосон байна.

Онцгой байдлын байгууллага нь 2003 онд нэгдсэн тогтолцоонд шилжснээс хойш албаны нохойг ашиглаж байгаагүй гэвэл бас өрөөсгөл ойлголт болно 2006 онд Онцгой байдлын ерөнхий газрын харъяа Аврах тусгай ангид 3 нохой болон 3 нохой хөтлөгч албан хаагчийг Гаалийн ерөнхий газрын эрэлч нохойн сургалтын төвд анх сурган бэлтгэж байсан түүхтэй бөгөөд түүнээс хойш сургалт явагдаагүй тасарсан нь албаны нохойг хөгжүүлэх бодлого, төлөвлөлтгүй санхүү хөрөнгө мөнгөний болон бусад хүчин зүйлээс шалтгаалан нохой сургах, үржүүлэх, ажиллагаанд ашиглах асуудал өнөөг хүртэл орхигдож тасарсан гэж үзэж байна.

Манай орны хувьд байгаль, цаг агаарын онцлого, нийгмийн хөгжлийн хурдац, хүн амын төвлөрөл, үйлдвэржилт зэргээс үүсэх шууд болон шууд бус аюул занал жилээс жилд өсөн нэмэгдэж буй өнөө үед аюулт үзэгдэл, ослын дараа эрэн хайх, аврах үйл ажиллагааг хүн болон дэвшилтэт техникийн тусламжтайгаар явуулахаас гадна албаны нохой /эрэлч нохой/-г ашиглах нь чухал хэрэгцээтэйг илэрхийлж байна.

Онцгой байдлын байгууллагад албаны нохойг дараах зүйлд сурган дадлагажуулах. Үүнд:

1. Нурангинаас эрэн хайх;
2. Уснаас эрэн хайх;
3. Тэсэрч дэлбэрэх бодисыг эрэн хайх;

4. Сураггүй болсон хүний үнэр мөрөөр эрэн хайх зэрэг ажиллагаанд сурган дадлагажуулж болзошгүй цагийн нөхцөл байдал үүссэн ямарч нөхцөлд тодорхой орон зайд богино хугацаанд эрлийн ажиллагаанд ашиглах практик ач холбогдолтой. Онцгой байдлын албаны хүч хэрэгслийн нэг хэсэгт тооцогдож болох албаны нохойн хангалт, ашиглалтыг сайжруулахад нохойн сургалтын төвийг цогцоор нь шинээр байгуулах түүнийг хөгжүүлэх тогтолцоог шинжлэх ухааны

онол арга зүйгээр оновчтой тодорхойлсон сургалтын хөтөлбөр, хэтийн /стратегий/ төлөвлөгөөг боловсруулан батлах шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Иймд нохойн сургалтын төвийг хөгжүүлэх төслийн үр дүнд буй болох сургалтын төв нь Онцгой байдлын албанд зориулан албаны нохойг үржүүлэх, сургаж бэлтгэх, хангахын зэрэгцээ албаны нохой сургагч, нохой хөтлөгч нарыг бэлтгэх сургах, дадлагажуулах улмаар гамшиг осолтой тэмцэх албаны бэлтгэл бэлэн байдлыг хангахад чухал хувь нэмэр оруулна.

Төв орон нутгийн онцгой байдлын албаны газар хэлтэст албаны нохойг сургаж бэлтгэх, нохойгоор хангах, тэдгээрийг давтан сургах, нохойн ажлын хүчин чадлыг хэвийн байлгах, албаны нохойн сургагч, хөтлөгч нарыг заавар, зөвлөмжөөр хангах, шалган туслах, уралдаан тэмцээн тогтмол зохион байгуулах нь тэдний мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх гол хүчин зүйл болно.

Сургалтын арга барил, хэлбэрийн хувьд бүсчилсэн, зайны, үндсэн, давтан, хэсэгчилсэн гэж төрөлжүүлэн явуулах нь эдийн засгийн хувьд хэмнэлттэй, цаг хугацаа хэмнэх зэрэг давуу талтай байдаг байна.

Албаны нохойн сургалт бол ихээхэн хариуцлагатай, бүтээлч хандлага, мэдлэг, тэвчээр, шургуу байхыг шаардсан асар хэцүү, нөр их хөдөлмөр байдаг нохой сургагч, хөтлөгч бэлтгэхэд давхар мэргэжил эзэмшүүлж мэргэшүүлэх сургагчийн туршлага, чадвар нохой хөтлөгчийн сонирхол зэргийг харгалзан судлан үзэх нь чухал юм.

Албаны нохойг байгууллагынхаа үндсэн чиг үүрэгт ашигладаг төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий цагдаа, тагнуул, хил хамгаалах, гааль, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албаны нохойн сургалтын төвийн үйл ажиллагааг судлах, ололттой болон дэвшилтэд зүйлийг нэвтрүүлэн харилцан хамтран ажиллах нь зүйтэй.

Иймээс онцгой байдлын байгууллагын үндсэн чиг үүрэгт нийцэх албаны нохойн сургалтын иж бүрэн төвийг шинээр бий болгох эрэн хайх, аврах чиглэлээр нохойг бэлтгэж өргөн хүрээтэйгээр тасралтгүй ашиглах нь албаны үндсэн үүргийг хэрэгжүүлэхэд өнөөгийн болон хэтийн хэрэгцээ шаардлагыг хангах үр дүнтэй ажил болно гэж судлаачийн хувьд үзэж байна.